

БАТЛАВ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

М.БАДАМСҮРЭН

**СУУРЬ ӨВЧЛӨЛТЭЙ БОЛОН ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ХҮҮХДҮҮДИЙГ
ЗУНЫ СУВИЛАЛД ХАМРУУЛАХ ТӨСЛИЙН АЖЛЫН ДААЛГАВАР**

Нийтлэг үндэслэл: Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д заасны дагуу сувилал нь эрүүл мэндийн байгууллагын хяналтанд хүүхдэд сэргээн засах, асаргаа сувилгаа хийх үндсэн чиг үүрэг бүхий байгалийн ус, агаар, шавар, шарлага бусад байгалийн хүчин зүйлийг ашиглаж сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлнэ.

Хэрэгжүүлэх чиглэл: Хэрлэн сумын суурь өвчлөлтэй зорилтот бүлгийн 130 хүүхдийг ор бүхий зуны сувиллыг түшиглэн хийнэ.

Хүүхдийн сувилал нь үйл ажиллагааныхаа хувьд 2 төрөлтэй байж болно.

1. Ортой сувилал /сувилуулагч тухайн сувилалд хоногоор үйлчлүүлэх/

2. Өдрийн сувилал /сувилуулагч тухайн сувилалд өдрөөр үйлчлүүлэх/

Сувилуулагчийн нэг удаагийн сувилгаа 7-10 хоног үргэлжилнэ.

Хоол тэжээлийн хурц болон архаг дутагдлаас үүдэлтэй рахит, тураал, цус багадалт зэрэг суурь өвчтэй онцгой асаргаа сувилгаа шаардлагатай хүүхдийг стандартын дагуу сувилах чийрэгжүүлэх, эрүүлжүүлэх, сэргээн засах чиглэлээр мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлнэ.

Сувилал нь үйл ажиллагаандаа дараах зарчим баримтална.

- Хүүхдэд ээлтэй аюулгүй орчныг стандартын дагуу бүрдүүлсэн байх
- Тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангасан байх
- Гэр бүл эцэг эхэд чирэгдэлгүй ил тод шуурхай нээлттэй үйлчилж шаардлагатай мэдээллээр хангах
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөн ажиллах
- Хүүхдийн мэргэжлийн эмчийн тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй үзүүлэх
- Сувилахуйн мэргэшсэн тусламж үйлчилгээг үзүүлэх
- Эцэг эх асран хамгаалагчдад зөв зохистой хоололт болон асран хамгаалалтын тухай мэдлэг хандлага дадлыг төлөвшүүлэх
- Сувиллын дараах жин нэмэгдэлт болон эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг тодорхойлох.

Хамрах хүрээ: Хоол тэжээлийн хурц болон архаг дутагдлаас үүдэлтэй сульдаа, жингийн алдагдал, цус багадалт зэрэг суурь өвчтэй онцгой асаргаа сувилгаа шаардлагатай 1-5 хүртэлх насны хүүхдийг асран хамгаалагчийн хамт хамруулна. Дорнод аймгийн Хэрлэн сумын 130 хүүхдийг хамруулна.

Хугацаа: 2024 оны 06 дугаар сарын 25-аас 8 дугаар сарын 30 хүртэл буюу зуны улиралд зохион байгуулна.

Санхүүжилтийн эх үүсвэр:

- Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан

Тавигдах шаардлага

№	Үзүүлэлт	Тайлбар
1	Сувилал нь зориулалтын байртай, эрүүл ахуйн болон хамгаалалтын бүс тогтоосон байх	1.1 Байр нь сувиллын үйл ажиллагааг үзүүлэх нөхцлийг бүрэн хангасан байна. /Тусгай хэрэгцээт хүүхдэд үйлчлэх нөхцлөөр хангагдсан байна./ 1.2 Эмчлүүлэгчийн өрөө 12м2 1.3 4 ортой өрөө 24м2 1.4 Усан дотор иллэг хийх ванны өрөө 18м2

1/2


		1.5 Эмчлүүлэгчийн болон ажилчдын ариун цэврийн өрөө 15 хүн тутамд 1 суултуур ажилчдад 305м2 1.6 Тарианы өрөө 12м2
2	Хүний нөөц	Эмнэлгийн мэргэжилтний тоо 80 хувиас дээш хангагдсан байна. 1. Хоол зүйч 2. Хүүхдийн мэргэжлийн их эмч 3. Сувилагч 4. Сэргээн засах сувилагч 5. Сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн 6. Тогооч бэлтгэгч 7. Угаагч 8. Үйлчлэгч
3	Сувилалд хэрэглэх эмнэлгийн хэрэгсэл багаж тоног төхөөрөмж аппарат хэрэгсэл	
	Чагнуур Даралтын аппарат Халуун хэмжигч Яаралтай тусламжийн иж бүрдэл	Эмчийн тоогоор Эмчийн тоогоор Хүрэлцэхүйц 1
3.1 Ороох боох материал		
	Даавуун боолт	1
	Даралттай боолт самбай	1
3.2 Тариур зүү		
	Нэг удаагийн тариур 20г, 10г, 5г, 3г, 1г дуслын систем	Яаралтай тусламжид шаардагдах хэмжээгээр
3.3 Сэргээн засах эмчилгээний аппарат тоног төхөөрөмж		
	-Дасгалын тоног төхөөрөмж, 3-4 төрлийн хэрэглэл иж бүрдэл -Эмчилгээний хугацаа тохируулах цаг -Өндөр хэмжигч -Цагираг -Сувиллын үйлчилгээнд нэн шаардлагатай аппарат	-Багц -Хүрэлцээтэй хэмжээгээр -Эмчилгээний өрөөнд
3.4 Нөхөн сэргээх эмийн бус байгалийн хүчин зүйлээс нөлөөх орчин нөхцөл		
	-Гаднаа хүүхдийн тоглоомын талбайтай -Элсэн болон усан наран шарлагын зориулалтын талбайтай -Шар шүүс -Усан эмчилгээ -Иллэг эмчилгээ -Хүчилтөрөгчийн коктейль эмчилгээ -Хөдөлгөөн засал эмчилгээ	Эмийн бус байгалийн хүчин зүйлсийг ашиглан эмчилгээнд эерэгээр нөлөөлөх орчин нөхцлийг бүрдүүлэх Хүүхдэд өдөр бүр элсэн болон наран шарлага тосон бариатай, орой бүр ясны шөл, хар цай, давстай усанд оруулах
4	Сувилахуйн тусламж үйлчилгээ	4.1 Сувилал нь зориулалтын өрөө тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. Сувилалын карт, зөвлөх эмчийн үзлэг, журам, журнал тэмдэглэлтэй байна. 4.2 Сэргээн засах тусламж үйлчилгээг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандартын дагуу явуулна.
5	Эмийн эмчилгээ	5.1.Эмчийн заалтаар эмийн эмчилгээг хийж болно.

6	Яаралтай тусламжийн үйлчилгээ	<p>6.1 Сувилал нь яаралтай тусламжийн нэгжтэй өвчтөнийг эрэмбэлэн ангилах яаралтай тусламж үзүүлэх онош тодруулах ажиглалт хийх, тусгаарлах, ариун цэврийн өрөөтэй байна.</p> <p>6.2 Тусгаарлах өрөө нь амьсгалын болон гэдэсний халдварын чиглэлээр эрүүл ахуй халдвар хамгаалалтын дагуу зөв зохион байгуулсан байна.</p> <p>6.3 Ар гэрийг яаралтай мэдээллээр хангана.</p>
7	Гамшиг онцгой байдлын үед үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	7.1 Гамшиг онцгой байдал, байгалийн болон хурц халдварт өвчний болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх эмчлэх бэлэн байдлыг хангаж ажиллана.
8	Оношилгоо	<p>8.1 Оношилгоо шинжилгээг магадлан итгэмжлэгдсэн бусад эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээгээр гүйцэтгүүлж болно.</p> <p>8.2 Мэргэшсэн эмч, сувилагч үзлэг хийнэ.</p>
9	Нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээ	<p>9.1 Хүүхэд асарч сувилах, хөдөлгөөн засал хийх талаар хөтөлбөр сургалтуудыг эцэг эхүүдэд зохион байгуулах</p> <p>9.2 Хүүхдийг хоол тэжээлд сайжруулах нэмэлт хоолны системтэй сургалтыг явуулах</p>
10	Хоол үйлчилгээ	<p>10.1 Хоол үйлчилгээний тасаг нэгж хэсэгтэй хүний нөөцтэй байна. Хоолны газрын стандарт дүрмийг баримталж аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна.</p> <p>10.2 Эмчилгээ сувиллын хоолны нормативыг мөрдөн ажиллана. /Өдрийн 6 хоолтой, төрөл бүрийн жимсний шүүс, цай, тараг, сүү, кекс, печень, сэндвич, жимс жимсгэнэ/</p> <p>10.3 Эрүүл мэндийн яамны Хоол судлалын төвийн зөвлөмжийн дагуу хоолны хэм хэмжээ, хооллох дэглэмийг өдөр тутамдаа мөрдлөг болгоно.</p> <p>10.4 Батлагдсан хоолны цэс удирдамж, жор технологиор хоолны илчлэг орц нормыг тооцон эрүүл ахуйн шаардлага хангасан нийтийн болон онош эмнэлзүйн шинж тэмдэгт нийцсэн эмчилгээний хоолоор үйлчилж хоол эмчилгээний үр дүнг үнэлж ажиллана.</p> <p>10.5 Эх орны хөрсөнд ургасан жимс жимсгэнэ, хүнсний ногоо, орон нутгийн мэргэжлийн байгууллагаас зөвшөөрөгдсөн мах махан бүтээгдэхүүнийг хэрэглэнэ.</p> <p>10.6 Гал тогооны технологийн урсгал, цэвэрлэгээ, үйлчилгээ, хооллох өрөөний тав тух, хоолны нэр төрөл бэлтгэн нийлүүлэлт, хоол хүнсний аюулгүй байдалд дотоодын болон хөндлөнгийн хяналтыг тогтмол хийнэ.</p>
11	Эмийн сангийн үйл ажиллагаа	11.1 Сувилал нь эмийн сан ажиллуулах бол зохих стандартын шаардлага хангасан байна.
12	Аж ахуй хатуу зөөлөн эдлэлийн ашиглалт хангалт	13.1 Төвлөрсөн ариутгал халдваргүйтгэлийн үйл ажиллагаа явуулах байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан гүйцэтгүүлж болно. Багаж хэрэгсэл материал аппарат тоног төхөөрөмжүүдийн угаалга, цэвэрлэгээ, халдваргүйтгэл ариутгалыг зохих дүрэм журмын дагуу хийнэ.
13	Угаалга цэвэрлэгээ	13.2 Эрүүл ахуйн шаардлага хангасан халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж ажиллана.
14	Хог хаягдал	13.3 Сувилал нь эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах ялгах цуглуулах, хадгалах, тээвэрлэх, халдваргүйтгэх, устгахад батлагдсан дүрэм журмыг мөрдөж ажиллана.

15	Барилга байгууламжийн эрүүл ахуйн шаардлага	14.1 Сувилал нь аянга цахилгаан зайлуулагч, газардуулагатай орчинг бүрдүүлнэ. 14.2 Сувиллын өрөө нь 18-20 с хэмээс доошгүй дулаантай агаарын солилцоо тогтмол хийх нөхцлийг бүрдүүлсэн байна. 14.3 Төвлөрсөн усан хангамжтай МУ-ын стандартын шаардлагыг хангасан байна. 14.4 Угаалтуур болон ариун цэврийн байгууламжийг шийдвэрлэсэн байна.
16	Гэрэлтүүлэг цахилгаан хангамж	15.1 Төвлөрсөн цахилгаан сүлжээнд холбогдсон байх. Нэмэлт цахилгааны үүсгүүртэй байх
17	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн орчны нөхцлийг хангасан байх	16.1 Тусгай нөхцөл шаардлагуудыг хангаж тусгай хэрэгсэл, зориулсан тэмдэг тэмдэглэгээтэй байна. 16.2 Тусгай хэрэгцээт тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.

БОЛОВСРУУЛСАН:
АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА  Ч.ОЮУНАА

ТАНИЛЦСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН
БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Э.ЭРДЭНЭБИЛЭГ

ХЯНАСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХӨГЖЛИЙН
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА  М.НЯМСҮРЭН